



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2025/099/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: "Пийк Ом аудит" ХХК Утас: 99052418 Цахим хаяг: cheegii9989@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-10
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	11-15
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11-12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12-13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11-12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	12-13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13-15
4. Аудитын тайлан	15-18
4.1 Ерөнхий зүйл	15-16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16-17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17-18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. Аудитын илрүүлэлт	18-19
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
НДШ	Нийгмийн даатгалын шитгэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**АЛТАНБУЛАГ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Б.ЭРДЭНЭ-ОЧИР ТАНАА**

2025.02.25 № СЭА-2025/099/НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд тус сургууль нь МУЗГ болон Герман улсын ЗГ-ын хамтарсан гэрээний дагуу “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн хүрээнд 34,610.2 мянган төгрөгийн тавилга эд хогшил, хичээлийн хэрэглэгдэхүүн, аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 17,910.0 мянган төгрөгийн техник хэрэгсэл, 39,850.4 мянган төгрөгийн өртөгтэй 240 метр халаалтын труба шинэчилж, үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн байна.

Тус сургууль нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/355 дугаар тушаалаар сургалтын байгууллагын

гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 3 дугаар түвшинд үнэлэгдэж, урамшуулалд 32,563.3 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас тус сургуулийн тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 9 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 18 зорилтын хүрээнд 57 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 96.3 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	338,870,699.94	359,142,717.92
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	142,170,462.40	136,869,511.08
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	142,170,462.40	136,869,511.08
3121	Төгрөг	142,170,462.40	136,869,511.08
31211	Төрийн сангийн харилцах	142,170,462.40	136,869,511.08
314	Замд яваа мөнгөн хөрөнгө		
33	АВЛАГА	152,411.01	2,581,921.81
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	152,411.01	2,581,921.81
34	УРЬДЧИЛГАА		
35	БАРАА МАТЕРИАЛ	196,547,826.53	219,691,285.03
351	Түүхий эд материал		217,200.00
3513	Эм боох материал		217,200.00
354	Хангамжийн материал	196,547,826.53	219,474,085.03
3541	Бичиг хэргийн материал	1,348,000.00	6,265,600.00
3542	Аж ахуйн материал	102,853,678.72	103,619,296.72
3544	Түлш, шатах тослох материал		126,000.00
3545	Барилгын засварын материал	1,590,400.00	1,974,400.00
3546	Хүнсний материал	5,710,180.00	
3547	Бусад хангамжийн материал	85,045,567.81	107,488,788.31
36	НӨӨЦИЙН БАРАА		
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,069,967,809.07	2,135,798,090.40
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,069,967,809.07	2,135,798,090.40
392	Биет хөрөнгө	1,823,507,809.07	1,890,724,090.40
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,695,817,070.84	1,695,817,070.84
39202	Хуримтлагдсан элэгдэл	-235,040,466.30	-283,180,305.42
39203	Авто-тээврийн хэрэгсэл	21,063,500.00	21,063,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-20,738,450.00	-21,063,500.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	354,823,760.47	466,134,135.91
39206	Хуримтлагдсан элэгдэл	-198,591,160.64	-246,183,828.71
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	133,185,916.06	168,221,494.49
39208	Хуримтлагдсан элэгдэл	-52,543,179.28	-61,740,809.31
39209	Зам, гүүрийн байгууламж	78,240,355.32	113,310,535.32
39210	Хуримтлагдсан элэгдэл	-3,221,354.41	-8,499,850.63
39214	Бусад үндсэн хөрөнгө	53,579,495.97	47,205,376.07
39215	Хуримтлагдсан элэгдэл	-14,512,064.17	-13,990,664.17
39217	Ном	11,444,385.21	13,630,936.01
393	Биет бус хөрөнгө	246,460,000.00	245,074,000.00
39301	Програм хангамж	7,810,000.00	7,810,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,652,000.00	-5,038,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	242,302,000.00	242,302,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,408,838,509.01	2,494,940,808.32
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	6,847,348.82	1,032,448.92
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,847,348.82	1,032,448.92
413	Өглөг	6,847,348.82	1,032,448.92
4131	Ажилчидтай холбогдсон өглөг		175,074.92
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	6,847,348.82	
4136	Бусад өглөг		857,374.00
41361	Байгууллагад төлөх өглөг		857,374.00

V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,401,991,160.19	2,493,908,359.40
51	Засгийн газрын хувь оролцоо	2,401,991,160.19	2,493,908,359.40
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,487,967,337.20	1,487,967,337.20
51101	Өмч: - төрийн		
512	Хуримтлагдсан үр дүн	-496,225,350.87	-394,865,431.66
5121	Өмнөх үеийн үр дүн	-496,225,350.87	-486,782,630.87
5122	Тайлант үеийн үр дүн		91,917,199.21
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,410,249,173.86	1,400,806,453.86
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,408,838,509.01	2,494,940,808.32

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,163,507,818.62	3,027,006,063.84
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	102,032,218.62	144,759,565.62
120	Нийтлэг татварын бус орлого	102,032,218.62	144,759,565.62
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,891,251.00	6,853,100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,710,903.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,180,348.00	6,853,100.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	73,825,569.00	120,804,045.12
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	19,315,398.62	17,102,420.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,061,475,600.00	2,882,246,498.22
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,832,914,100.00	2,630,298,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,832,914,100.00	2,630,298,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		6,800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		6,800,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	228,561,500.00	245,147,698.22
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	228,561,500.00	245,147,698.22
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,118,857,859.03	2,925,541,494.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,118,857,859.03	2,925,541,494.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,003,789,889.03	2,799,798,964.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,355,258,085.67	2,014,696,188.11
210101	Үндсэн цалин	838,355,527.46	1,128,198,740.03
210102	Нэмэгдэл	334,005,668.21	719,712,790.16
210104	Урамшуулал	182,896,890.00	166,784,657.92
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	166,427,947.73	247,297,046.70
210201	Тэтгэврийн даатгал	110,137,947.73	170,996,734.36
210202	Тэтгэмжийн даатгал	14,072,500.00	19,901,086.98
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,257,800.00	10,341,018.37
210204	Ажилгүйдлийн даатгал	2,814,400.00	9,151,657.27
210205	Эрүүл мэндийн даатгал	28,145,300.00	36,906,549.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	227,466,248.82	227,307,749.40
210301	Гэрэл, цахилгаан	16,280,363.28	17,531,271.95
210302	Түлш, халаалт	189,330,861.54	187,306,378.57

210303	Цэвэр, бохир ус	21,855,024.00	22,470,098.88
2104	Хангамж, бараа материалын зардал	1,300,000.00	5,460,932.00
210402	Тээвэр, шатахуун	1,300,000.00	
210408	Бараа материал акталсны зардал		5,460,932.00
2105	Нормативт зардал	61,167,650.00	69,900,450.00
210502	Хоол, хүнс	61,167,650.00	69,900,450.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,588,670.00	10,183,300.00
210604	Урсгал засвар	14,588,670.00	10,183,300.00
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,951,056.40	23,251,518.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,710,800.00	4,508,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,240,256.40	18,743,218.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	164,630,230.41	201,701,780.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,526,660.00	60,441,066.63
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,992,809.40	14,536,320.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	113,110,761.01	126,724,394.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	115,067,970.00	125,742,530.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	115,067,970.00	125,742,530.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	86,235,970.00	93,993,330.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,832,000.00	31,749,200.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	44,649,959.59	101,464,569.00
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		9,547,369.79
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		9,547,369.79
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		-9,547,369.79
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	44,649,959.59	91,917,199.21

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,070,366,851.00	2,889,956,972.22
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,891,251.00	7,710,474.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,891,251.00	7,710,474.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,891,251.00	6,853,100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,710,903.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,180,348.00	6,853,100.00
120009	Бусад орлого		857,374.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,061,475,600.00	2,882,246,498.22
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,832,914,100.00	2,630,298,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,832,914,100.00	2,630,298,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		6,800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		6,800,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	228,561,500.00	245,147,698.22
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	228,561,500.00	245,147,698.22
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,011,654,335.89	2,813,959,923.54

21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,011,654,335.89	2,813,959,923.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,894,810,035.89	2,693,758,723.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,354,576,291.74	2,014,696,191.11
210101	Үндсэн цалин	900,832,449.12	1,136,263,545.14
210102	Нэмэгдэл	370,423,224.78	711,647,988.05
210104	Урамшуулал	83,320,617.84	166,784,657.92
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	166,374,639.75	249,551,479.58
210201	Тэтгэврийн даатгал	110,084,639.75	165,150,492.58
210202	Тэтгэмжийн даатгал	14,072,500.00	21,179,129.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,257,800.00	10,636,188.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,814,400.00	10,418,161.00
210205	Эрүүл мэндийн даатгал	28,145,300.00	42,167,509.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	220,618,900.00	234,155,098.22
210301	Гэрэл, цахилгаан	13,031,254.16	22,031,071.17
210302	Түлш, халаалт	187,256,300.00	187,306,378.57
210303	Цэвэр, бохир ус	20,331,345.84	24,817,648.48
2104	Хангамж, бараа материалын зардал		
2105	Нормативт зардал	61,366,500.00	69,731,600.00
210502	Хоол, хүнс	61,366,500.00	69,731,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,942,600.00	10,992,600.00
210604	Урсгал засвар	7,942,600.00	10,992,600.00
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,799,756.40	31,393,213.90
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,710,800.00	4,508,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,088,956.40	26,884,913.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	67,131,348.00	83,238,540.73
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	50,346,900.00	63,508,940.73
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,784,448.00	19,729,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	116,844,300.00	120,201,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	116,844,300.00	120,201,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	88,012,300.00	88,452,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,832,000.00	31,749,200.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	58,712,515.11	75,997,048.68
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	48,048,800.00	81,298,000.00
	Дотоод эх үүсвэрээр	48,048,800.00	81,298,000.00
223001	Бусад хөрөнгө	48,048,800.00	81,298,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-48,048,800.00	-81,298,000.00
145	Бусад эх үүсвэр		
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал		
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	10,663,715.11	-5,300,951.32
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		142,170,462.40

31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		136,869,511.08
----	---	--	----------------

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,487,967,337.20	1,410,249,173.86	-496,225,350.87	2,401,991,160.19
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			9,442,720.00	9,442,720.00
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		-9,442,720.00		-9,442,720.00
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
17	Тайлант үеийн үр дүн			91,917,199.21	91,917,199.21
19	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,487,967,337.20	1,400,806,453.86	-394,865,431.66	2,493,908,359.40

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,033,057,200.00	2,895,257,923.54	137,799,276.46	95.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,033,057,200.00	2,895,257,923.54	137,799,276.46	95.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,912,856,000.00	2,775,056,723.54	137,799,276.46	95.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,128,360,000.00	2,014,696,191.11	113,663,808.89	94.7
210101	Үндсэн цалин	1,306,907,800.00	1,136,263,545.14	170,644,254.86	86.9
210102	Нэмэгдэл	714,538,200.00	711,647,988.05	2,890,211.95	99.6
210104	Урамшуулал	106,914,000.00	166,784,657.92	-59,870,657.92	156.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	266,045,100.00	249,551,479.58	16,493,620.42	93.8
210201	Тэтгэврийн даатгал	180,910,600.00	165,150,492.58	15,760,107.42	91.3
210202	Тэтгэмжийн даатгал	21,283,600.00	21,179,129.00	104,471.00	99.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,641,800.00	10,636,188.00	5,612.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	10,641,800.00	10,418,161.00	223,639.00	97.9
210205	Эрүүл мэндийн даатгал	42,567,300.00	42,167,509.00	399,791.00	99.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	235,954,700.00	234,155,098.22	1,799,601.78	99.2
210301	Гэрэл, цахилгаан	23,764,700.00	22,031,071.17	1,733,628.83	92.7
210302	Түлш, халаалт	187,306,300.00	187,306,378.57	-78.57	100.0
210303	Цэвэр, бохир ус	24,883,700.00	24,817,648.48	66,051.52	99.7
2104	Хангамж, бараа материалын зардал			0.00	
2105	Нормативт зардал	69,731,600.00	69,731,600.00	0.00	100.0
210502	Хоол, хүнс	69,731,600.00	69,731,600.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,992,600.00	10,992,600.00	0.00	100.0

210604	Урсгал засвар	10,992,600.00	10,992,600.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал			0.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52,210,700.00	49,021,213.90	3,189,486.10	93.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,783,100.00	4,508,300.00	2,274,800.00	66.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	45,427,600.00	44,512,913.90	914,686.10	98.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	149,561,300.00	146,908,540.73	2,652,759.27	98.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	129,831,700.00	127,178,940.73	2,652,759.27	98.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,729,600.00	19,729,600.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	120,201,200.00	120,201,200.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	120,201,200.00	120,201,200.00	0.00	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	88,452,000.00	88,452,000.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	31,749,200.00	31,749,200.00	0.00	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ			0.00	
	Дотоод эх үүсвэрээр			0.00	
223001	Бусад хөрөнгө			0.00	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,033,057,200.00	2,889,956,972.22	143,100,227.78	100.0
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,772,629,800.00	2,637,098,800.00	135,531,000.00	100.3
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,630,298,800.00	2,630,298,800.00	0.00	100.0
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	142,331,000.00		142,331,000.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		6,800,000.00	-6,800,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		6,800,000.00	-6,800,000.00	
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	246,947,300.00	245,147,698.22	1,799,601.78	99.3
132001	Орон нутгийн төсвөөс	246,947,300.00	245,147,698.22	1,799,601.78	99.3
133	ТӨСВИЙН ЗАХИРАГЧДААС			0.00	
134	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ			0.00	
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	13,480,100.00	7,710,474.00	5,769,626.00	50.8
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,680,100.00		6,680,100.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,800,000.00	6,853,100.00	-53,100.00	100.8
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР		857,374.00	-857,374.00	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		142,170,462.40	142,170,462.40	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		136,869,511.08	136,869,511.08	
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	73	73	0.00	100.0
6	Удирдах ажилтан	3	3	0.00	100.0
7	Гүйцэтгэх ажилтан	47	47	0.00	100.0
8	Үйлчлэх ажилтан	21	21	0.00	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1. БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургууль нь “Сурагч, багш, асран хамгаалагчийн хамтын оролцоонд суурилан боловсролын хүртээмж чанарыг сайжруулах, суралцагчдын авьяас чадвар, бие даан суралцах чадварыг дэмжин хамтран ажиллана” гэсэн зорилгын хүрээнд:

- Бие даан суралцах арга зүйг дэмжин сургалтын чанарт ахиц гаргана;
- Багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэн хамтран суралцана;
- Эрүүл зөв дадалд суралцан байгууллага болон сургуулийн соёлыг бий болгоно гэсэн зорилт тавин ажилласан байна.

3.2. Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;*
- *Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал

дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус сургууль нь БШУС-ын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, шинжлэх ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургууль нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 86,102.3 мянган төгрөгөөр буюу 3.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
МӨНГӨН ХӨРӨНГӨ	142,170.5	136,869.5	-5,301.0
АВЛАГА	152.4	2,581.9	2,429.5
БАРАА МАТЕРИАЛ	196,547.8	219,691.3	23,143.5
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,069,967.8	2,135,798.1	65,830.3
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,408,838.5	2,494,940.8	86,102.3
НИЙТ ӨР ТӨЛБӨР	6,847.3	1,032.4	-5,814.9
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО	2,401,991.2	2,493,908.4	91,917.2
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,408,838.5	2,494,940.8	86,102.3

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 136,869.5 мянган төгрөг болж 5,301.0 мянган төгрөгөөр буурсан нь мөнгөн хөрөнгийн зарцуулалттай холбоотой;

- Авлага дансны үлдэгдэл 2,581.9 мянган төгрөг болж 2,429.5 мянган төгрөгөөр өссөн нь тооцооллын алдаанаас нийгмийн даатгалын шимтгэлийг илүү шилжүүлсэнтэй холбоотой;
- Бараа материал дансны үлдэгдэл 219,691.3 мянган төгрөг болж 23,143.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 233,515.3 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авсан, Боловсролын яамнаас 9,169.1 мянган төгрөгийн түрээсийн ном, хичээлийн хэрэглэгдэхүүн, МУЗГ болон Германы ЗГ-ын хамтарсан “Уур амьсгалын өөрчлөлт” төслөөс 7,933.3 мянган төгрөгийн сургалтын хэрэглэгдэхүүнийг үнэ төлбөргүй авч, орлогоор бүртгэсэн болон 5,460.9 мянган төгрөгийн бараа материалыг зохих шийдвэрийн дагуу акталж данс бүртгэлээс хассан, 222,013.3 мянган төгрөгийн хөрөнгийг үйл ажиллагаанд зарцуулснаас шалтгаалсан байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 2,775,495.1 мянган төгрөг болж 177,228.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 81,298.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, машин тоног төхөөрөмж худалдан авсан, “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн хүрээнд 26,676.9 мянган төгрөгийн, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 17,910.0 мянган төгрөгийн, Боловсролын яамнаас 36,366.7 мянган төгрөгийн, 39,850.4 мянган төгрөгийн өртөгтэй 240 метр халаалтын труба шинэчилсэн зэрэг 120,804.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэж, сумын ИТХ-ын 2024 оны 141 дүгээр тогтоолын дагуу 24,873.5 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассантай холбоотой байна. Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн эцсийн үлдэгдэл 639,696.9 мянган төгрөг бөгөөд хөрөнгийн үлдэгдэл өртөг 2,135,798.1 мянган төгрөг байна.
- Өр төлбөр дансны үлдэгдэл 1,032.4 мянган төгрөг болж 5,814.9 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны өр төлбөрийг бүрэн барагдуулж, тайлант оны эцэст НДС-аас 857.4 мянган төгрөгийн ХЧТА тэтгэмж орж ирснийг өглөгөөр бүртгэсэн, тооцооллын алдаанаас 175.0 мянган төгрөгийн ХХОАТ өглөг шинээр үүссэн зэргээс шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,332,520.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 244,978.7 мянган төгрөг зэрэг нийт 2,577,499.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг цалин НДШ-н зардлыг 139,980.4 мянган төгрөгөөр, хоолны зардлыг 5,732.7 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 12,107.4 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 318,839.0 мянган төгрөгөөр, **нийт 476,659.5**

мянган төгрөгөөр бууруулж, тогтмол зардлыг 5,438.0 мянган төгрөгөөр, мэдээлэл технологийн үйлчилгээний зардлыг 24,452.9 мянган төгрөгөөр, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 2,713.4 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 84,563.6 мянган төгрөгөөр, нийт 117,167.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, төсвийг 2,218,007.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант 2024 онд 9 удаа төсвийн зохицуулалт хийгдэж, улсын төсвөөс 2,630,298.8 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 246,947.3 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлогоос 13,480.1 мянган төгрөгийн, урьд оны үлдэгдлээс 142,331.0 мянган төгрөг зарцуулахаар зэрэг төсвийг нийт 3,033,057.2 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Цалин, НДШ-ийн зардлыг 728,555.3 мянган төгрөгөөр,
- Тогтмол зардлыг 5,538.2 мянган төгрөгөөр,
- Хоолны зардлыг 6,696.3 мянган төгрөгөөр,
- Урсгал зардлыг 3,100.0 мянган төгрөгөөр,
- Мэдээлэл технологийн үйлчилгээний зардлыг 9,607.9 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 6,783.1 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 15,431.7 мянган төгрөгөөр,
- Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 39,371.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж,
- Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 34.0 мянган төгрөгөөр бууруулсан гэх мэт.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 15 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсний дагуу нийт 3,033,057.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 2,895,257.9 мянган төгрөгийг зарцуулж, 137,799.3 мянган төгрөгийг хэмнэж, үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,895,257.9 мянган төгрөг буюу 95.5 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
1	71802 Ерөнхий боловсрол	1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	4,884.5	4,884.5	-	100.0
		2	80233 Хүүхэд хамгаалал	5,100.2	5,100.2	-	100.0
		3	80312- Сургалт семинар	3,481.4	3,481.4	-	100.0
		4	81605- Эрүүл мэндийг дэмжих	7,205.9	6,260.2	945.7	86.9
		5	81801- Үдийн цай хөтөлбөр	88,452.0	88,452.0	-	100.0
		6	81806 Дотуур байр	254,852.1	244,291.3	10,560.8	95.9
		7	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	39,555.0	39,555.0	-	100.0
		8	81823- Боловсролын багшийн сургалт	14,653.5	14,653.5	-	100.0
		9	81827 Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	11,912.9	11,912.9	-	100.0
		10	81834- Боловсролын стандарт сургалт	2,170,478.8	2,049,175.1	121,303.7	94.4

	11	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	164,134.5	164,134.5	-	100.0
	12	81875- Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	7,816.0	6,901.3	914.7	88.3
	13	81848-Сурах бичгийн түрээс	6,783.1	4,508.30	2,274.8	66.5
	14	83603- Дээд шатны төсвөөс	6,800.0	6,800.0	-	100.0
	15	80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	246,947.3	245,147.7	1,799.6	99.3
	Нийт		3,033,057.2	2,895,257.9	137,799.3	95.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хаасан байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАУХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

/ мянган төгрөгөөр /				
№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Тендер шалгаруулалтын арга
1	Дотуур байрны хоол	69,731.6	63,035.3	НТШ
2	Үдийн цай	88,452.0	88,029.0	НТШ
Нийт дүн		158,186.6	151,064.3	

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалт /Анхны батлагдсан төсвөөр тендерийн үнийн саналыг өгсөн/ -ыг 2 удаа зарлаж, гүйцэтгэгчээр шалгарсан “Бумбат арвижих” ХХК-тай 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр гэрээ байгуулж, худалдан авалтыг гүйцэтгэжээ.

Тайлант онд хоол хүнс, цэвэрлэгээний материалыг Бумбат арвижих ХХК, бичиг хэрэг, ахуйн бараа, нэг удаагийн хамгаалах хэрэгсэл, Цахим Ертөнц ХХК, урсгал засварын материалыг "Сэлэнгэ титан" ХХК-тай тус тус худалдан авах гэрээ байгуулан ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн /цаашид Алтанбулаг сумын ерөнхий боловсролын

сургууль гэх/ 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу "Пийк Ом Аудит" ХХК-ийн аудитор Б.Наранчимэг гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургууль нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "дунд" гэж үнэллээ.

